

## Сэтгүүлд эх хүлээж авах журам

1. Тус сэтгүүл нь гастроэнтеролог төдийгүй анагаах ухааны бусад салбарыг хамарсан эрдэм шинжилгээ судалгаа, тойм лекц , шүүмж, орчуулга, мэдээлэл, шинэ эм, клиникийн ховор тохиолдлын болон уламжлалт анагаах ухааны тухай материалыг хүлээж авах болно.
2. Зохиогч нь овог нэр, ажлын хаяг, харилцах утсаа тодорхой бичнэ.
3. Материал нь шинжлэх ухаан болон арга зүйн өндөр түвшинд бичигдсэн, орчин үеийн тугамдсан асуудлыг хөндсөн, шинэ мэдээллээр баялаг, эмчилгээ үйлчилгээнд нэвтрүүлэх бололцоотой байх ба эмч нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд дөхөм болох ёстой.
4. Шинжилгээ судалгааны өгүүлэл нь статистик боловсруулалт хийгдсэн, судалгааны ажлын үндэслэл, зорилго, үр дүн, дүгнэлт зэрэг дарааллаар бичиж , товч дүгнэлт нь англи хэл дээр байна.
5. А4 хэмжээтэй цаасанд, 46 мөрөөр бичигдсэн , 1-5 хуудас бүхий материалын өнгөн хувийг авна. Хэрэв эхийг компьютерт бэлтгэсэн бол дараах байдлаар бичвэл бидний ажлийг хөнгөвчлөх болно. Гарчгийг 12 / bold-оор тодотгосон / агуулгыг 11, зохиогч ба дүгнэлт, ашигласан ном зүйг 10 шрифтээр , Arial mon фондоор, дээд, доод, баруун, зүүн талаас 2.5 см зайтай бичнэ.
6. Канондсон материал хүлээж авахгүй.
7. Ирүүлсэн материалд ашигласан хэвлэлийн жагсаалтыг зохиогч, хэвлэл, он, дугаар, хуудсын хамт тодорхой заана.
8. Материалд орсон зураг нарийн хүснэгт зэргийг 2% явуулна.
9. Сэтгүүлийн зөвлөл өгүүллийн утгыг алдагдуулахгүй засах , боловсруулалт хийх боловч зохиогчийн эрхийг хүндлэх ба шаардлага хангаагүй материалыг нийтлэхгүй.
10. хэвлэлд орсон материалыг буцаахгүй.
11. Бусад сэтгүүл , хэвлэлд гарсан материалыг хүлээн авахгүй.
12. Сэтгүүлд гарах материал нь зохих төлбөртэй байна.
13. Оны эцэст шилдэг өгүүлэл бичсэн зохиогчийг шалгаруулах болно.
14. Сэтгүүлд нийтлэх материалыг 99110120 утсаар хүлээн авна.